

ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛ

ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН ХУРАЛДААН – Хуралдааны тойм

ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН ХУРАЛДААНААР ХЭЛЭЛЦСЭН АСУУДЛЫН ХӨТӨЛБӨР ¹ 24 (ТОЙМ)

Хуралдаан 2009 оны 11 дүгээр сарын 19-ний өдрийн 14.40 цагт эхэлж, 17.40 цаг хүртэл Засгийн газрын Х1 байрын 301 тоот өрөөнд болж, нийт 3 цаг 00 минут үргэлжлэв.

1	Хэлэлцсэн асуудал	Гарсан шийдвэр
1	МУ-ын ЗГ-ын тохируулагч агентлаг Стандартчилал, хэмжил зүйн газрын дэд даргын албан тушаалд томилогдох удирдах ажилтанд дүгнэлт гарган, нэр дэвшүүлэх тухай	МУ-ын ЗГ-ын тохируулагч агентлаг Стандартчилал, хэмжил зүйн газрын дэд даргын албан тушаалд Гүржавын Энхтайванг томилуулахаар дүгнэлт гарган нэр дэвшүүлж Монгол Улсын тэргүүн шадар сайд Н.Алтанхуягт санал болгох тухай МУ-ын ТАЗ-ийн тогтоол гаргахаар тогтов.
2	МУ-ын ЗГ-ын хэрэгжүүлэгч агентлаг Ойн газрын дэд даргын албан тушаалд томилогдох удирдах ажилтанд дүгнэлт гарган, нэр дэвшүүлэх тухай	МУ-ын ЗГ-ын хэрэгжүүлэгч агентлаг Ойн газрын дэд даргын албан тушаалд Дэмбэрэлийн Болдмягмарыг томилуулахаар дүгнэлт гарган нэр дэвшүүлж Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Л.Гансүхэд санал болгох тухай МУ-ын ТАЗ-ийн тогтоол гаргахаар тогтов.
3	МУ-ын ЗГ-ын хэрэгжүүлэгч агентлаг Оюуны өмчийн газрын хэлтсийн дарга нарын албан тушаалд томилогдох ажилтны сонгон шалгаруулалтын тухай	ЗГ-ын хэрэгжүүлэгч агентлаг Оюуны өмчийн газрын хэлтсийн дарга нарын албан тушаалд томилогдох ажилтны сонгон шалгаруулалтын тухай асуудлыг тус газарт бүтцийн өөрчлөлтийг нь судалж үзээд албан тушаал бүр дээр чиг үүрэг нь өөрчлөгдөж үү, үгүй юу гэдгийг нь комисс томилон ажиллуулж, хүн нэг бүр дээр тодруулаад дараагийн хуралдаанаар шийдвэрлүүлэхээр хойшлуулав.
4	Хөвсгөл аймгийн Засаг даргын 2009 оны 11 дүгээр сарын 06-ны өдрийн 333 дугаар захирамжийн тухай	1.Хөвсгөл аймгийн Засаг даргын 2009 оны 11 дүгээр сарын 06-ны өдрийн 333 дугаар захирамжийг хүчингүй болсонд тооцох, 2.ТАТХ-ийн 39.6-д заасны дагуу энэхүү тогтоолыг биелүүлэх арга хэмжээ авахыг Хөвсгөл аймгийн Засаг дарга Л.Цэрэнжавт мэдэгдэх тухай МУ-ын ТАЗ-ийн тогтоол гаргахаар тогтов.
5	УИХ-ын гишүүн асан Б.Эрдэнэсүрэнг төрийн албаны нөөцөд бүртгэх тухай	2004-2008 онд УИХ-ын гишүүнээр сонгогдон ажиллаж байсан, МУ-ын сайд, ЗГ-ын ХЭГ-ын дарга Б.Долгорын 2008 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн 213 дугаар тушаалаар МУ-ын Ерөнхий сайдын ахлах зөвлөхөөр томилогдон ажиллаж байгаа Баатарын Эрдэнэсүрэнг төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөцийн жагсаалтад бүртгэх тухай МУ-ын ТАЗ-ийн тогтоол гаргахаар тогтов.

6	Онцгой байдлын асуудал эрхэлсэн байгууллагын төрийн тусгай албан тушаалд анх орох иргэнээс төрийн жинхэнэ албаны мэргэшлийн шалгалт авах журмын төслийн тухай	<p>1.Онцгой байдлын асуудал эрхэлсэн байгууллагын төрийн тусгай албан тушаалд анх орох иргэнээс төрийн албаны мэргэшлийн шалгалт авах журмын төслийн үндэслэлийг баталж, Ажлын хэсэг дахин редакци хийж ажиллаад 11 дүгээр сарын 24-ний дотор Ажлын журмаар батлахаар болов.</p> <p>2.Бусад төрийн тусгай байгууллагуудаас тэдгээрийн тус тусын боловсруулсан дээрх журмын төслийг нь 12 дугаар сарын 07-ны өдрийн дотор авч, ондоо багтааж төрийн тусгай бүх байгууллагын энэ журмын төслийг батлуулахыг ТАЗ-ийн ахлах референт Х.Шаандарт даалгав.</p>
7	Монгол Улсын Засгийн газрын тохируулагч агентлаг Тагнуулын ерөнхий газрын дэргэдэх Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн бүрэлдэхүүнийг шинэчлэн батлуулах тухай	МУ-ын ЗГ-ын тохируулагч агентлаг Тагнуулын ерөнхий газрын дэргэдэх Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн шинэчилсэн бүрэлдэхүүнийг: Даргаар –Тагнуулын ерөнхий газрын дарга, гишүүдэд: Есдүгээр газрын орлогч дарга, Төрийн тусгай хамгаалалтын газрын дарга, Төрийн холбооны газрын МАБХ хэлтсийн дарга, Нэгдүгээр газрын нэгдүгээр хэлтсийн дарга, Хоёрдугаар газрын нэгдүгээр хэлтсийн дарга, Аюулгүй байдлын албаны дарга, Архив, бүртгэлийн хэлтсийн дарга, Салбар зөвлөлийн нарийн бичгийн даргаар хүний нөөцийн хэлтсийн дарга нарын 9 хүний бүрэлдэхүүнтэйгээр байгуулах тухай МУ-ын ТАЗ-ийн тогтоол гаргахаар тогтов.
8	Монгол Улсын Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Газрын харилцаа, барилга, геодези, зураг зүйн газрын дэргэдэх Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн тухай	Хойшлуулав.
9	Зарим хүмүүсийг “Төрийн албаны тэргүүний ажилтан” цол, тэмдгээр шалгаруулан шагнах тухай	Д.Баяндүүрэн, Н.Болд, Ж.Булган, Д.Ганхүү, М.Даваасүрэн, Ч.Долзод, Ц.Долоонжин, С.Доржсумъяа, Р.Жадамбаа, Ж.Жамбал, Ж.Жуков, Ц.Зина, А.Лхагваа, Г.Лхагвасүрэн, Л.Мөнхөө, Х.Намсрай, Ж.Наран, Г.Нина, Н.Оюунаа, М.Оюунбат, Т.Сүнгийдорж, Т.Төмөрчөдөр, Б.Тунгалаг, Л.Түвдэнням, Т.Цагаанхишиг, Д.Цэнд, Б.Цэрэнханд, Б.Цэцэгдарь, Г.Цэцэгдэлгэр, Ш.Чулуунхүү, Ц.Шаравдорж, Б.Энхтуяа, Р.Эрдэнэбаатар нарын 33 хүнийг “Төрийн албаны тэргүүний ажилтан” цол, тэмдгээр шалгаруулан шагнаж, уг шагналд дагалдах мөнгийг МУ-ын ТАЗ-ийн 2009 оны 47 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Төрийн албаны тэргүүний ажилтан цол, тэмдгээр шагнах журам”-ын 4.2-т заасны дагуу тухайн байгууллагаас олгох тухай МУ-ын ТАЗ-ийн даргын шийдвэр гаргахаар тогтов.